



**ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ**

**“ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГА”- ЫН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН
ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2020 он**

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Нэг. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ

Хуулийн төсөлд хуулийн этгээдэд шинээр үүрэг хүлээлгэж, захиргааны зардлыг нэмэгдүүлэх нэг чиглэлийн зохицуулалт тусгагдсан байна:

1. Төмөр замын тээвэрт зарим үйл ажиллагаа эрхлэх, тодорхой эрх эзэмшиж, ашиглахад тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хуульчилсан нь:

Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 2007 оны Төмөр замын тээврийн тухай хуульд Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 7-н чиглэлээр *төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг олгож байна. Үүнд суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүн угсрах, үйлдвэрлэх засварлах, мөн тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохоор хуульчилсан бол хуулийн шинэчилсэн найрууллагад энэхүү тусгай зөвшөөрлийн 10 чиглэлээр олгохоор зохицуулсан байна. Урьд нь гэрчилгээгээр олгож байсан “Салбар зам байгуулах эрх”/12.2.2/, мөн журмаар зохицуулж байсан хоёр асуудал болох “Төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний зураг төсөл боловсруулах техник, технологийн хяналт тавих, зөвлөх үйлчилгээ үзүүлэх”/12.2.9/, “Төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнд техникийн үзлэг оношилгоо хийх” /12.2.10/ зэрэг зохицуулалтыг оруулсан байна.*

Зам, тээврийн хөгжлийн яамнаас одоо мөрдөгдөж байгаа хуулийн дагуу төмөр замын суурь бүтэц угсрах тусгай зөвшөөрөл олгож байгаа хэдий ч, мөн хуулийн “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам”/15.1.10/-аар салбар зам барих тэмдэгтийн хураамжгүйгээр салбар зам барих эрх давхардуулан олгодог байсныг шинэчлэн найруулгын хуулийн төсөл дээр давхардлыг арилгасан болно.

2017 онд 79 иргэн, хуулийн этгээдэд 137 дагнасан хэрэглээний салбар замын гэрчилгээ, 2018 онд 53 иргэн, хуулийн этгээдэд 103 гэрчилгээ тус тус олгосон байна. Энэ ойролцоогоор жилд дунджаар 66 иргэн, хуулийн этгээдэд 120 дагнасан хэрэглээний салбар замын гэрчилгээ олгож байна.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай болон Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дагуу 5 сая төгрөгийн дагуу ойролцоогоор Улсын төсөвт 930 сая төгрөг орлого төвлөрүүлэх боломжтой.

Улсын хэмжээнд төрийн захиргааны төв байгууллагаас төмөр зам суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн угсрах, үйлдвэрлэх, засварлах, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр болон сунгахаар сүүлийн гурван жилийн дунджаар 10-иад аж ахуй нэгж байгууллага хуулийн этгээд **17.5 орчим тусгай зөвшөөрөл олгосон**. Төмөр замын салбарт төмөр замын үйл ажиллагаанд оруулснаар тухайн хуулийн этгээдийн хувьд хуулиар тогтоосон нөхцөл, шаардлагад нийцүүлэн баримт материалыг бэлтгэж эрх бүхий байгууллагад хүргүүлж, зөвшөөрөл авахтай холбоотойгоор урьдчилсан тооцооллоор **гурван жил тутам 28 671 мянган төгрөгийн нэмэлт захиргааны зардал** үүсэх ба төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьд жилд **738 мянган төгрөгийн захиргааны зардал үүсч** байна. Түүнчлэн, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар тусгай зөвшөөрөл хүсэгчийн хувьд Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дагуу тэмдэгтийн хураамж

төлөхтэй холбоотойгоор нэг хуулийн этгээдийн хувьд 5.03 сая төгрөгийн нэмэлт зардал гарахаар байна.

Хоёр. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Хуулийн төсөлд хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн операторыг улсын бүртгэлд бүртгэх иргэн болон хуулийн этгээдэд байхаар тусгасан байна.

“Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператор” гэж хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг өмчилдөг, хууль буюу гэрээний дагуу эзэмшдэг, тээвэрлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг ашиглуулах үйлчилгээ үзүүлэхээр тээвэрлэлтэд оролцож байгаа тээвэрлэлтийн бичиг баримтад заасан иргэн, хуулийн этгээдийг/4.1.39/“мөн хуульд “Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, дугаар, гэрчилгээ олгох/11.2.8/”

Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль дээр хөдлөх бүрэлдэхүүнийг бүртгэх асуудлын Төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт өргөдлөө гаргаж байсан бол шинэчилсэн хуулийн төсөл дээр иргэний Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвд хүсэлтээ гаргана гэж өөрчилсөн.

Гэхдээ энэ хөдлөх бүрэлдэхүүнийг бүртгэх хуулийн зохицуулалт өмнө нь байсан харин **чингэлгийг бүртгүүлэх** төрийн зүгээс хуулийн хэрэгжилтийг иргэдэд хангахын тулд тус шинээр зохицуулалтыг оруулсан.

Төмөр замын тээврийн шинэчилсэн найруулгад *“Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг улсын бүртгэлд бүртгэснийг нотолж дугаар, гэрчилгээ олгох/40.5/”-оор* тусгагдсан.

Чингэлгийг эрх бүхий байгууллагад бүртгүүлэхтэй холбоотойгоор жилд ойролцоогоор **38 565 төгрөгийн захиргааны зардал үүсэх ба жилд 8300 чингэлгийг бүртгэхэд 328 567 мянган төгрөгийн захиргааны зардал үүсч** байна.

Гурав. ТООН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүрэг хэчнээн хуулийн этгээдэд, нэг жилд хэдэн удаагийн давтамжтайгаар үүрэг хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Тоон үзүүлэлтийг дараах байдлаар тооцов:

- тухайн үүргийг хүлээх хуулийн этгээдийн тоо (тохиолдлын тоо);
- тухайн үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо (давтамж);
- *Тохиолдлын тоо*: Улсын хэмжээнд холбогдох эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн дагуу 7 ангиллаар нийтийн тээврийн үйлчилгээг эрхэлдэг байна:

Төмөр замын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо

№	Тусгай зөвшөөрлийн ангилал	Тусгай зөвшөөрөл олгосон, хугацаа				Дундаж
		2016	2017	2018	2019	
1	Суурь бүтэц угсрах	10	9	14		11
2	Суурь бүтэц засварлах	1	1	3		1.7
3	Суурь бүтэц үйлдвэрлэх	2	-	3		1.7
4	Хөдлөх бүрэлдэхүүн угсрах	1	-	2		1
5	Хөдлөх бүрэлдэхүүн засварлах	-	-	3		1
6	Хөдлөх бүрэлдэхүүн үйлдвэрлэх	-	-	1		0.3
7	Тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх	-	-	2		0.6
Нийт тоо		14	10	28		17.3

2019 онд гэрчилгээ хүссэн болон гэрчилгээний талаар лавлагаа хүссэн нийт 286 хүсэлт ирснээс 107 хүсэлт бүхий баримт бичгийн бүрдлийг гэрчилгээ олгох журмын шаардлага хангаагүй шалтгаанаар буцааж, 164 хүсэлтийг шийдвэрлэн, үлдсэн 15 хүсэлт шийдвэрлэгдэх шатандаа явж байгаа болно.

Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар 2019 оны IV улирлын байдлаар дагнасан хэрэглээний салбар замд 112, зүтгүүрт 9, вагонд 296, төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаанд 60, нийт 745 төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой 3-5 жилийн хугацаатай гэрчилгээг 143 хуулийн этгээдэд гэрчилгээ олгон ажилласан.

Дээрх мэдээллээс үзэхэд улсын хэмжээнд жилд 10-аад орчим хуулийн этгээд төмөр замын тусгай зөвшөөрлийн дагуу үйлчилгээ эрхэлдэг байна. Иймд зардлын тооцооллын хүрээнд тохиолдлын тоог сүүлийн 3 жилийн дунджаар буюу 17.3 гэж үзлээ.

Давтамж: Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хуульд тусгай зөвшөөрлийг 3 жилээс доошгүй хугацаагаар олгохоор заасны дагуу жилд ногдох давтамжийг 0.33 тооцсон болно.

Тоон үзүүлэлт=17.3*0.33=5.7

■ **Хуулийн этгээдэд үүсэх нийт захиргааны зардлын тооцоо:**

Энэ хэсэгт өмнөх шатанд тооцож гаргасан стандарт үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэхтэй холбогдон гарах зардал болон тоон үзүүлэлтийг үржүүлж нийт захиргааны зардлын дүнг гаргана.

T

Нийт зардлын тооцооны дүн

Бүрдүүлэх баримт, материал	Стандарт үйл ажиллагаа	Нэгж зардал /төгрөг/	Тоон үзүүлэлт	Зардал
Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл	Өргөдөл бичих	778.60	5.7	4445.8
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, санхүүгийн тайлангийн хуулбар	Олшруулах	389.3		2222.9
	Нотариатаар баталгаажуулах	1167.9		6668.7
Шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл	Олшруулах	1167.9		6668.7
	Нотариатаар баталгаажуулах	2335.8		13337.4
Санхүүгийн чадавхын мэдээлэл	Олшруулах	1167.9		6668.7
	Нотариатаар баталгаажуулах	2335.8		13337.4
Тусгай зөвшөөрлийн төрлөөс хамааран шаардлагатай тохиолдолд зураг төсөл	Боловсруулах	11211.8		640196.1
Холбогдох маягтын дагуу гаргах хуулийн этгээдийн мэдээлэл	Маягтыг дагуу бөглөх	4671.6		26674.8
	Олшруулах	2335.8		13337.4
Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт	Мөнгө шилжүүлэх	778.6	4445.8	
Нийт		129 247.6		738003.8

Хуулийн төсөлд салбар зам барих асуудлыг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаанд хамааруулснаар нэг хуулийн этгээдийн хувьд урьдчилсан тооцооллоор гурван жил тутам 129 247.6 мянган төгрөгийн нэмэлт захиргааны зардал үүсэх ба үйлчилгээ эрхлэгч хуулийн этгээдийн хувьд жилд **738 003.8 төгрөгийн захиргааны зардал үүсч** байна.

**Дөрөв. “ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН НЭГДСЭН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГА” БУЮУ ТӨРИЙН
БАЙГУУЛЛАГЫН ЗАРДАЛ**

Төмөр замын тээврийн салбарын 2012 оны үйл ажиллагааны тоон үзүүлэлт харьцуулахад **25-50%-**иар өсөж, салбар дахь аж ахуйн нэгжийн тоо, ашиглагдаж буй хөдлөх бүрэлдэхүүний тоо нэмэгдэж байгаа нь /хавсралтаас үзэх/ салбар дахь төрийн үйлчилгээг нэмэгдүүлэх, боловсронгуй болгох зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Хуулийн төслийн 11 дүгээр бүлэгт “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв”- ийн үйл ажиллагааны гүйцэтгэх үүргийг илүү тодорхой болгож, эрх үүргийг нэмэгдүүлэн байгууллагын нэрийг нь “**Төмөр замын тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын асуудал хариуцсан байгууллага**” гэж өөрчилж, эрх зүйн харилцааг зохицуулахаар хуульчлагдсан.

“Төмөр замын тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын асуудал хариуцсан байгууллага” нь хуулийн төсөлд тусгаснаар төмөр замын салбарт төрийн бодлого, зохицуулах үйлчилгээ үзүүлнэ.

Гүйцэтгэх үүрэгт хөдөлгөөний нэгдсэн зурмагийг боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, шинжилгээ хийх, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын оновчтой байдал, төмөр замын дэд бүтцийн нэвтрүүлэх чадвар ашиглалт, хөдлөх бүрэлдэхүүний хуваарилалт, зохицуулалтад дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн дэд бүтэц эзэмшигчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, төмөр замын тээврийн хүртээмжтэй байдлыг хянах, тээвэрлэгч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператор, тээвэр зуучлагчийн тэгш оролцоог хангуулах, тээвэрлэлтийн статистикийн тайлан мэдээг улсын хэмжээнд нэгтгэх, дүн шинжилгээ хийж, төмөр замын дэд бүтцүүдийн техникийн нормчлолын биелэлтэд хяналт тавих, хилийн боомт, дэд бүтцүүдийн уулзварын өртөөнд галт тэрэг солилцох үйл явцад хяналт тавих, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, дугаар, гэрчилгээ олгох, Монгол Улсын хэмжээнд төмөр замын дэд бүтцүүдийн хооронд хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн харилцан хуваарилалтад зохицуулалт хийх, төмөр замын дэд бүтцийн хориглолд ашиглагдах радио зурвасыг эзэмших, ашиглах, хувиарлах чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан.

“Төмөр замын тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын асуудал хариуцсан байгууллага” нь хуулийн төсөлд тусгаснаар төмөр замын салбарт төрийн бодлого, зохицуулах үйлчилгээ үзүүлнэ.

Урьдчилсан тооцооллоор галт тэрэгний нэгдсэн төв нь одоогийн орон тоогоор шинэчилсэн хуулийн төсөлд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэж үзэж байна.

4.1. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх хэсэгт заасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу алхам тус бүрийн хүрээнд мэдээлэл цуглуулан, стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэн тооцооллыг дараах үе шатаар хийсэн болно:

- Байгууллагын шинээр гүйцэтгэх үүргийг тогтоох;
- Хүний нөөцийн зардлын тооцоолол;
- Тоон үзүүлэлтийг үндэслэсэн тооцоолол /төрийн үйлчилгээнээс шинээр бий болох орлого, зардал/
 - Нийт зардлын дүнгийн тооцоолол;
 - Зардал хэмнэх хялбарчлах боломжуудыг хэрхэн ашигласан талаарх дүгнэлт.

Төмөр замын тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын асуудал эрхэлсэн байгууллага”-ын гүйцэтгэх чиг үүргийн харьцуулалт

Д/д	Одоо дагаж мөрдөж байгаа хуулийн заалт	Хуулийн төслийн заалт
Чиг үүрэг, бүрэн эрх		
Тээврийн нэгдсэн удирдлагын хэлтэс	14.1. галт тэрэгний төв нь төмөр замын байгууллагуудын галт тэрэгний хөдөлгөөнийг уялдуулан зохицуулах чиг үүрэгтэй.	11.2.1. төмөр замуудын галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийг боловсруулах, батлах, гүйцэтгэлд хяналт тавих, шинжилгээ хийх;
	14.2. хөдөлгөөн зохицуулалтын төвийн ажиллах журмыг төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмээр тодорхойлно.	11.2.2. төмөр замын дэд бүтэц эзэмшигч хооронд ачаа солилцох гэрээг бүртгэх, технологийн нэгдмэл бодлогоор хангах;
	14.3.1. хөдөлгөөний нэгдсэн зурмагийг батлах;	11.2.3. төмөр замын зангилаа өртөөдийн нэгдсэн технологийн горимыг баталж, техникийн норматив биелэлтэд хяналт тавих;
	14.3.2. хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд суурь бүтцүүдийн хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг захирамжлан зохион байгуулах	11.2.4. төмөр замын тээврийн статистик тайлан, мэдээг улсын хэмжээнд нэгтгэх, дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгууллагад мэдээлэх;
Гэрчилгээжүүлэлт хөдлөх бүрэлдэхүүний хэлтэс	14.3.3. суурь бүтэц эзэмшигч хоорондын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын харилцан уялдааг хангах;	11.2.5. төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосны дагуу олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудтай хамтран ажиллах, хилийн төмөр замуудын зөвлөгөөнд оролцох, санал, зөвлөмжийг дэвшүүлэх;
	14.3.4. галт тэрэгний хөдөлгөөний удирдлагатай холбоотой санал, дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх;	11.2.6. хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, дугаар, гэрчилгээ олгох, баталгаажуулах;
	14.3.5. галт тэрэгний хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэхэд чиглэсэн суурь бүтэц эзэмшигчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;	11.2.7. төмөр замын тээврийн зарим бүтээгдэхүүн, үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, гэрчилгээ, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтыг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох талаар эрх бүхий байгууллагад санал оруулах;
	14.3.6. тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын байгууллагын нэгдсэн технологийн горимыг боловсруулах;	11.2.8. төмөр замын тээвэрлэлтийн талаар иргэд байгууллагын гомдлыг хүлээн авах шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
	14.3.7. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.	11.2.9. холбогдох хууль тогтоомжид заасны дагуу төмөр замын дэд бүтцийн дохиолол холбоо, сүлжээний радио зурвасыг ашиглах, хуваарилах;
		11.2.10. төмөр замын мэргэжлийн ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох ажлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах;
		11.2.11. төмөр замын тээвэрт гарсан сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан шалтгааныг шинжлэн судалж, шинжээчийн дүгнэлт гаргах, арга хэмжээ авах;

	11.2.12. төмөр замын салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухаан технологийн бодлогыг хэрэгжүүлэх;
	11.2.13. Төмөр замын дэд бүтэц, салбар замын хувийн хэрэг хөтлөх, төмөр замын тээврийн салбарын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх.

Дөрөвдүгээр хүснэгт

**Төмөр замын тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын асуудал
эрхэлсэн байгууллагын гүйцэтгэх үүрэг**

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт	Үүрэг
11.2.1. Төмөр замуудын галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийг боловсруулах, батлах, гүйцэтгэлд хяналт тавих, шинжилгээ хийх;	1. Нэгдсэн зурмаг боловсруулах – жилд 2 удаа 2. Дэд бүтэц хоорондын зөвлөгөөн зохион байгуулах -4 удаа 3. Зурмагын биелэлтийн талаар судалгаа дүгнэлт, зөвлөмж - жилд 2 удаа
11.2.2. Төмөр замын дэд бүтэц эзэмшигч хооронд ачаа солилцох гэрээг бүртгэх, технологийн нэгдмэл бодлогоор хангах;	4. Тайлан боловсруулж, илгээх – ЗТХЯ –д сар бүр 5. Дэд бүтцүүдийн тайлан хүлээн авах- сар бүр
11.2.3. Төмөр замын зангилаа өртөөдийн нэгдсэн технологийн горимыг баталж, техникийн норматив биелэлтэд хяналт тавих;	6. Зурмагын тасалдалын судалгаа гаргах – тогтмол 7. Зурмагын шинжилгээний тайлан – сар бүр
11.2.4. Төмөр замын тээврийн статистик тайлан, мэдээг улсын хэмжээнд нэгтгэх, дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгууллагад мэдээлэх;	1. Төмөр замын салбарын жил, хагас жил, улирал, сар, хоногийн мэдээг хугацаанд нь төмөр замын байгууллагуудаас гаргуулан авах- тогтмол 2. Тайланг боловсруулах /шууд өнгөрөх ачаа, галт тэрэг солилцоо г,м/ – тогтмол 3. Тайланг зохих байгууллагуудад илгээх – тогтмол 4. Боловсруулалт хийж салбарын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх- тогтмол
11.2.5. Төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосны дагуу олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудтай хамтран ажиллах, хилийн төмөр замуудын зөвлөгөөнд оролцох, санал, зөвлөмжийг дэвшүүлэх;	1. Хөрш орнууд болон бүс нутгийн төмөр замын мэдээллийн нэгдсэн системд нэвтрэх, мэдээлэл боловсруулах- тогтмол 2. Олон улсын байгууллагатай хамтран ажиллах /ОСЖД, Койка, Жайка болон бусад/ 3. Хилийн төмөр замуудын зөвлөгөөнд оролцох – жилд 3 удаа 4. Төмөр замын салбарт ойрын үед хэрэгжүүлэх боломжтой шинэ техник технологийн судалгааны тайлан- жилд 1 удаа./1сард/
11.2.6. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, дугаар, гэрчилгээ олгох, баталгаажуулах;	1. Шинээр орж ирж буй хөдлөх бүрэлдэхүүнийг бүртгэх, дугаар олгох-тогтмол 2. Түүрээсээр ашиглаж буй вагонуудыг бүртгэх, хяналт тавих - тогтмол 3. Гэрчилгээ олгох / шинээр/ -тогтмол 4. Төлбөр хураамж төвлөрүүлэх -тогтмол 5.Хөдлөх бүрэлдэхүүний улсын тооллого хийх –жилд 1 удаа 6. Бүртгэлийн нэгдсэн систем хөгжүүлэх-тогтмол
11.2.7. Төмөр замын тээврийн зарим бүтээгдэхүүн, үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, гэрчилгээ, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтыг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох талаар эрх бүхий байгууллагад санал оруулах;	1. Тохирлын үнэлгээний сургалтанд хамрагдах, зохион байгуулах – улирал бүр 2. Тохирлын үнэлгээ гаргах- тогтмол 3. Төмөр замын салбарын стандарт боловсруулах -жилд 2 удаа 4. Гэрчилгээ, тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой хүсэлт хүлээн авах- тогтмол 5. Гэрчилгээ тусгай зөвшөөрөлтэй холбоотой бичиг баримтын бүрдлийг шалгах –тогтмол

	<p>6. Гэрчилгээ тусгай зөвшөөрөл олгох- тогтмол</p> <p>7. Гэрчилгээ тусгай зөвшөөрөл олгохтой ажлын талаар мэдээлэлийн сан бүрдүүлэх, олон нийтэд сурталчлах - тогтмол,</p> <p>8. Мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, хөтлөх, архивлах.</p>
<p>11.2.8. Төмөр замын тээвэрлэлтийн талаар иргэд байгууллагын гомдлыг хүлээн авах шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;</p>	<p>1. Гомдол /бичгээр, мэдээллийн хэрэгслээр/ хүлээн авах- тогтмол</p> <p>2. Гомдолтой холбоотой асуудлын талаар холбогдох байгууллагад мэдэгдэх /албан бичиг/-тогтмол</p> <p>3. Гомдолын шийдвэрийг хангаж, бүртгэх-тогтмол</p> <p>4. Гомдол мэдээлэлийн сан бүрдүүлэх –тогтмол</p> <p>5. Гомдлын менежментийн программ хангамж хөгжүүлэх-тогтмол</p>
<p>11.2.9. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу төмөр замын дэд бүтцийн дохиолол холбоо, сүлжээний радио зурвасыг ашиглах, хуваарилах;</p>	<p>1. Радио зурвасын бүртгэлийг хөтлөх –тогтмол</p> <p>2. Шинээр радио зурвас эзэмших хүсэлт хүлээн авах- тогтмол</p> <p>3. Радио зурвасыг хувиарлах –тогтмол</p> <p>4. Шаардлагатай орлогыг төвлөрүүлэх-тогтмол</p> <p>5. Ашиглалт, хувиарлалтад хяналт тавих-тогтмол</p>
<p>11.2.10. Төмөр замын мэргэжлийн ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох ажлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах;</p>	<p>1. Мэргэжлийн инженерүүдийн бүртгэлийг хөтлөх-тогтмол</p> <p>2. Мэргэжлийн зэрэг олгох шалгалтыг зохион байгуулах-тогтмол</p> <p>3. Давтан сургалтуудыг байгууллага тус бүрээр бүртгэх- тогтмол</p> <p>4. Мэргэжлийн зэргийн үнэмлэх олгох, сунгах-тогтмол</p> <p>5. Онлайн сургалт явуулах - тогтмол</p>
<p>11.2.11. Төмөр замын тээвэрт гарсан сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан шалтгааныг шинжлэн судалж, шинжээчийн дүгнэлт гаргах, арга хэмжээ авах;</p>	<p>1. Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдлыг газар дээр нь шалгах комисс зохион байгуулах- ослын тохиолдол бүрт</p> <p>2. Шалтгаан нөхцлийг тогтоох, дүгнэлт гаргах-ослын тохиолдол бүрт</p> <p>3. Зөвлөмж гарган, ослоос урьдчилан сэргийлэх талаар мэдээ, мэдээлэл, заавар зөвлөмж гарган олон нийтийн сүлжээгээр сурталчлах- тогтмол.</p>
<p>11.2.12. Төмөр замын салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухаан технологийн бодлогыг хэрэгжүүлэх;</p>	<p>1. Төмөр замын салбарын хөгжлийн бодлого төлөвлөлтийн уялдаа холбоо хангах, стратеги инновацийн төлөвлөгөөг боловсруулах – жил бүр ,</p> <p>2. Салбарын урт хугацааны үр ашиг, өрсөлдөх чадварыг хангахад чиглэсэн шинэ нээлт санал, санаачлагыг дэмжих олон нийтийн үйл ажиллагаа зохин байгуулах - жилд 2 удаа;</p> <p>3. Салбарын стратегитай холбогдсон урт хугацааны төсөл хэрэгжүүлэх–1 удаа /3-аас дээш жил/</p> <p>4. Тулгамдаж буй асуудлын талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хийж сонин сэтгүүлд нийтлүүлэх, ном бичих, олон улсын хурал зөвлөгөөнд оролцох- жилд 1 удаа</p>
<p>11.2.13. Төмөр замын дэд бүтэц, салбар замын хувийн хэрэг хөтлөх, төмөр замын тээврийн салбарын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх;</p>	<p>1. Салбар замуудын бүртгэл хөтлөх –тогтмол</p> <p>2. Салбар замуудын хувийн хэргийг бүрдүүлэх-тогтмол</p> <p>4. Хяналтын тооллого хийх - жилд 1 удаа</p> <p>3. Бүртгэлийн нэгдсэн сан үүсгэх -тогтмол</p>

4.2. Шинээр үүсэж байгаа үүрэгтэй холбоотой шаардагдах хүний нөөц, түүний зардлын тооцоолол

“Төмөр замын тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын асуудал эрхэлсэн байгууллага”-ын хувьд дараах үүргүүдийг биелүүлэхэд нэмэлт орон тоо, түүнтэй холбоотой зардал шаардлагатай.

Тавдугаар хүснэгт

Хуулийн төслийн 11 дэх заалттай холбоотой зардлын тооцоо

Д/д	Хуулийн төслийн заалт	Шинээр нэмэгдэх орон тоо
11.2.6.	11.2.6.хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, дугаар, гэрчилгээ олгох, баталгаажуулах;	2
11.2.7.	11.2.7. төмөр замын тээврийн зарим бүтээгдэхүүн, үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, гэрчилгээ, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтыг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох талаар эрх бүхий байгууллагад санал оруулах;	2
11.2.8.	11.2.8. төмөр замын тээвэрлэлтийн талаар иргэд байгууллагын гомдлыг хүлээн авах шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;	1
11.2.10.	11.2.10. төмөр замын мэргэжлийн ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох ажлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах;	2
11.2.11.	11.2.11. төмөр замын тээвэрт гарсан сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан шалтгааныг шинжлэн судалж, шинжээчийн дүгнэлт гаргах, арга хэмжээ авах	2
11.2.12.	11.2.12. төмөр замын салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухаан технологийн бодлогыг хэрэгжүүлэх;	1
11.2.13.	11.2.13. Төмөр замын дэд бүтэц, салбар замын хувийн хэрэг хөтлөх, төмөр замын тээврийн салбарын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх.	1
	НИЙТ	11

4.3. Хуулийн заалт бүрт холбогдох ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлсон дэлгэрэнгүй тооцоолол:

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр хуулийн этгээдэд үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргана. Хуулийн этгээдийн зүгээс үүргийг хэрэгжүүлэх хүрээнд хийх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлж, тус бүрт зарцуулах хугацаа болон ажлын хөлсийг тогтоох шаардлагатай.

Зардлыг тооцохдоо дараах хүчин зүйлийг тооцов

- А. үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлох;
- Б. тухайн үйлдэлд зарцуулагдах хугацааг тогтоох;
- В. тухайн үйлдлийг хийх ажилтны ажлын хөлсийг тодорхойлох.

Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлыг тооцохдоо стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэнэ. Мөн тус жагсаалтад багтаагүй үйл ажиллагаанд жагсаалт гаргаж, ажиглалт

болон ярилцлагын аргуудыг ашиглан тухайн үүргийг гүйцэтгэх хугацааг тодорхойлно. Цаг хугацааг тооцохдоо зарцуулах хугацааг минутаар тооцож гаргана.

Хуулийн төслийн 11.2.6-г Хөдлөх бүрэлдэхүүн чингэлгийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, дугаар гэрчилгээ олгох, баталгаажуулах ажилд нэг ажилтанд зарцуулагдах хугацаа, зардал, шаардагдах ажилтны тоог тооцоолов.

Зургаадугаар хүснэгт

Хөдлөх бүрэлдэхүүн чингэлгийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, дугаар гэрчилгээ олгох ажлын зардал

Бүрдүүлэх баримт, материал	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа /минут/	Төгрөг	
			Ажлын хөлс	зардал
Дугаар олгохыг хүссэн өргөдөл	Өргөдөл хүлээн авах, бүртгэх	20	124.21	2484.2
Холбогдох бичиг баримтыг тулгаж шалгах	Мэдээлэл өгөгдөхүүн нягтлах /вагоны тех.паспорт, гэрээ,гаалийн мэдүүлэг шалгах/	40	124.21	4968.4
Дугаар олгох зөвшөөрөл авах	Маягт бөглөх, программд мэдээлэл оруулах	35	124.21	3726.3
Бүртгэлийн програм хангамжид бүртгэх	Тоо баримтыг шалгаж оруулах	7	124.21	869.47
Вагоны техникийн паспорт, гэрчилгээг бэлтгэх	Программд шивэх, хэвлэх	30	124.21	3726.3
Дугаар олгох	Стандартын дагуу боловсруулах	20	124.21	2484.2
Програмд оруулах	Нэгдсэн санд бүртгэж, програмд оруулах	10	124.21	1242.1
Хэвлэн нийтлэх	Тухайн бүртгэлийг зарлах	60	124.21	7452.6
Нийт		222		26,940.3

Тайлбар: Хугацаа х Ажлын хөлс=Үйл ажиллагаа тус бүрийн зардал.

Хүний нөөцийн хэрэгцээ=зарцуулах хугацаа×тохиолдлын тоо:

2019 онд 950 хөдлөх бүрэлдэхүүн шинээр бүртгэгдсэн. Хууль хэрэгжсэнээр 2020 оноос 2–р улирлаас улсын хэмжээнд байгаа 8305 хөдлөх бүрэлдэхүүнийг гэрчилгээжүүлэх ажил эхэлнэ.

$$3.7 \text{ цаг} * 1650 = 6105 \text{ цаг}$$

Нийт цаг / нэг ажилтаны жилийн ажлын цаг = Хэрэгцээт ажилтны тоо

$$6105 \text{ цаг} / 1936 \text{ хүн/цаг} = 3,15 \text{ хүн} = 3$$

Хуулийн төслийн 11.2.7. Төмөр замын тээврийн зарим бүтээгдэхүүн, үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, гэрчилгээ, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтыг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээхтэй холбоотой нэг ажилтанд зарцуулагдах хугацаа, зардал, шаардагдах ажилтны тооны тооцоолол.

Долдугаар хүснэгт

Тусгай зөвшөөрөл, гэрчилгээний материалыг хянах ажилтны зардлын тооцоо

Бүрдүүлэх баримт, материал	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа /минут/	Төгрөг	
			Ажлын хөлс	Зардал
Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл	Өргөдөлтэй танилцах	20	124.21	2484.2
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, санхүүгийн тайлангийн хуулбар	Хянан шалгах	60	124.21	7453
Шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл	Хянан шалгах	30	124.21	3726
Санхүүгийн чадавхийн мэдээлэл	Хянан шалгах	30	124.21	3726
Тусгай зөвшөөрлийн төрлөөс хамааран шаардлагатай тохиолдолд зураг төсөл	Хянан шалгах	30	124.21	3726
Холбогдох маягтын дагуу гаргах хуулийн этгээдийн мэдээлэл	Хянан шалгах	30	124.21	3726
Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт	Хянан шалгах	10	124.21	1242
Шаардлагатай тохиололд нэмэлт мэдээллийг авах	Утсаар холбогдох	20	124.21	2484.2
	И-мэйл илгээх			
Шийдвэрлэх	Төвийн удирдлагаар шийдвэрлүүлэх	90	124.21	11179
Тусгай зөвшөөрөлтэй байгууллагын үйл ажиллагаанд тооллого дүгнэлт гаргах	Байгууллага дээр үнэлгээ хийх	300	124.21	
Нийт		620	124.21	39.746.4

Тайлбар: Хугацаа x Ажлын хөлс=Үйл ажиллагаа тус бүрийн зардал.

Наймдугаар хүснэгт

Төмөр замын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо

№	Тусгай зөвшөөрлийн ангилал	Тусгай зөвшөөрөл олгосон, хугацаа			Дундаж
		2017	2018	2019	
1	Суурь бүтэц угсрах	9	14	48	23.67
2	Суурь бүтэц засварлах	1	3	2	2
3	Суурь бүтэц үйлдвэрлэх	-	3	2	1.67
4	Хөдлөх бүрэлдэхүүн угсрах	-	2	-	0.67
5	Хөдлөх бүрэлдэхүүн засварлах	-	3	2	1.67
6	Хөдлөх бүрэлдэхүүн үйлдвэрлэх	-	1	-	0.33
7	Тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх	-	2	-	0.67
Нийт тоо		10	28	54	30.6

Дээрх мэдээллээс үзэхэд улсын хэмжээнд жилд 10-аад орчим хуулийн этгээд төмөр замын тусгай зөвшөөрлийн дагуу үйлчилгээ эрхэлдэг байна. Иймд зардлын тооцооллын хүрээнд тохиолдлын тоог сүүлийн 3 жилийн дунджаар буюу 30.6 гэж үзлээ. Мөн жил бүр тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо 2 дахин өссөн харагдаж байна. Тусгай зөвшөөрөл сунгах үйл ажиллагаа тухайн жилд хийгдэх тул тохиолдлын тоог 2 дахин тооцоолов.

Хүний нөөцийн хэрэгцээ=Зарцуулах хугацаа×Тохиолдлын тоо:

$$10.3 \text{ цаг} * 60 = 620$$

Нийт цаг / нэг ажилтаны жилийн ажлын цаг = Хэрэгцээт ажилтны тоо

$$620 \text{ цаг} / 1936 \text{ хүн/цаг} = 0,32 = 1 \text{ Хүн} / \text{ажлын нөөц цагтай тул давхар үүрэг}$$

хүлээхээр тооцоолов/

Есдүгээр хүснэгт

**Тусгай зөвшөөрөл, гэрчилгээ олгохтой холбоотой бичиг баримт
хүлээн авах ажилтны тооцоолол**

Стандарт үйл ажиллагаа	Хугацаа /минут/	Төгрөг	
		Ажлын хөлс	Зардал
Бичиг баримтын бүрдлийг хүлээн авах	20	124.21	2484.2
Хянагдсан бичиг баримтын бүрдлийг Төрийн захиргааны төв байгууллагад шийдвэрлүүлэхээр хүргэж өгөх	60	124.21	7452.6
Сайдын тушаалыг үндэслэн тусгай зөвшөөрлийн эхийг бэлдэх	90	124.21	11178.9
Тусгай зөвшөөрлийг хэвлэх	60	124.21	1242.1
Сайдаар батлуулахаар Төрийн захиргааны төв байгууллагад хүргэн өгөх	60	124.21	7452.6
Тусгай зөвшөөрлийг олгох, бүртгэлжүүлэх	30	124.21	3726.3
Мэдээллийн сан баяжуулах	30	124.21	3726.3
Бичиг баримтыг архивлах	90	124.21	11178.9
Нийт	440	124.21	54646.9

Тайлбар: Хугацаа х Ажлын хөлс=Үйл ажиллагаа тус бүрийн зардал.

2019 онд гэрчилгээ хүссэн болон гэрчилгээний талаар лавлагаа хүссэн нийт 286 хүсэлт ирснээс 107 хүсэлт бүхий баримт бичгийн бүрдлийг гэрчилгээ олгох журмын шаардлага хангаагүй шалтгаанаар буцааж, 164 хүсэлтийг шийдвэрлэн, үлдсэн 15 хүсэлт шийдвэрлэгдэх шатандаа явж байгаа болно.

Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар 2019 оны IV улирлын байдлаар дагнасан хэрэглээний салбар замд 112, зүтгүүрт 9, вагонд 296, төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаанд 60, нийт 745 төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой 3-5 жилийн хугацаатай гэрчилгээг 143 хуулийн этгээдэд гэрчилгээ олгон ажилласан. Төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой эрс өсөж байгаа тул тохиолдлын тоог 150-иар, сунгах тохиолдолыг 50-иар тооцоолов.

Хүний нөөцийн хэрэгцээ=Зарцуулах хугацаа×Тохиолдлын тоо:

$$7.3 \text{ цаг} * 200 = 1466$$

Нийт цаг / нэг ажилтаны жилийн ажлын цаг = Хэрэгцээт ажилтны тоо

$$1466 \text{ цаг} / 1936 \text{ хүн/цаг} = 0,75 = 1 \text{ Хүн}$$

Тав. Хуулийн төслийн 11.2.8. Төмөр замын тээвэрлэлтийн талаар иргэд байгууллагын гомдлыг хүлээн авах шийдвэрлэх ажлын нэг ажилтанд зарцуулагдах хугацаа, зардал, шаардагдах ажилтны тооны тооцоолол

Аравдугаар хүснэгт

Гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх ажлын зардлын тооцоо

Бүрдүүлэх баримт	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа, минут	Ажлын хөлс	Зардал
Гомдлын өргөдөл	Өргөдөл бичих	15	124.21	1863.1
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ	И-мэйл ирүүлэх, нотариатаар баталгаажуулах	15	124.21	1863.1
Шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл	Олшруулах, нотариатаар баталгаажуулах	60	124.21	7452.6
Санхүүгийн чадавхийн мэдээлэл	Баталгаажуулах	30	124.21	3726.3
Гомдлын үнэлгээ гаргуулах төсөв	Боловсруулах	60	124.21	7452.6
Холбогдох маягтаар гаргах хуулийн этгээдийн мэдээлэл	Маягт бөглөх, олшруулах	30	124.21	3726.3
Улсын тэмдэгтийн хураамж төлөх	Төлбөр төлөх	15	124.21	1863.1
Нийт		210	124.21	27947.1

Тайлбар: Хугацаа х Ажлын хөлс=Үйл ажиллагаа тус бүрийн зардал.

Хүний нөөцийн хэрэгцээ=Зарцуулах хугацаа×Тохиолдлын тоо

/Төмөр замын салбарт 500 гаруй аж ахуйн нэгж, 18 гаруй мянган ажилтан ажиллаж, давхардсан тоогоор 3 сая гаруй зорчигч үйлчлүүлж байна. Гомдлын тохиолдлыг 0,03% иар тооцож 905.4 тохиолдлоор тооцоолов.

$$3.5 \text{ цаг} * 905.4 = 3168 \text{ цаг}$$

Нийт цаг /нэг ажилтаны жилийн ажлын цаг=Хэрэгцээт ажилтны тоо

$$3168 \text{ цаг} / 1936 \text{ хүн/цаг} = 1.6 \text{ хүн} = 1$$

Зургаа. Хуулийн төслийн 11.2.10. Төмөр замын мэргэжлийн ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох ажлын нэг ажилтанд зарцуулагдах хугацаа, зардал, шаардагдах ажилтны тооны тооцоолов.

Арваннэгдүгээр хүснэгт

Мэргэжил дээшлүүлэх, зэрэг олгох сургалтын бүртгэл хийх зардлын тооцоо

Бүрдүүлэх баримт, материал	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа /минут/	Төгрөг	
			Ажлын хөлс	Зардал
Сургалтын бүртгэлийн талаар мэдээлэл дамжуулах	Утсаар	10	124.21	1242.1
	Онлайнаар	10	124.21	1242.1
Сургалтын бүртгэл хийх	Утсаар	10	124.21	1242.1
	Биетээр	20	124.21	2484.2
	Онлайнаар	15	124.21	1863.15
Сургалтанд бүртгүүлэгчийн материалыг хүлээн авах	Биетээр	15	124.21	1863.15
	Онлайнаар	30	124.21	3726.3
Цахим сургалт явуулах	Биетээр	30	124.21	3726.3
	Онлайнаар	30	124.21	3726.3
Сургалтанд бүртгүүлэгчийн материалыг хадгалах, мэдээллийн нэгдсэн санд оруулах	Цаасан хэлбэрээр	20	124.21	2484.2
	Цахимаар	25	124.21	3105.25
Нийт		275	124.21	26977.6

Тайлбар: Хугацаа х Ажлын хөлс=Үйл ажиллагаа тус бүрийн зардал.

Хүний нөөцийн хэрэгцээ=Зарцуулах хугацаа×Тохиолдлын тоо
/Төмөр замын салбарт 16600 ажилтан 3500 гаруй мэргэжлийн инженер техникийн ажилтан ажиллаж байна. Мэргэжлийн зэрэг дээшлүүлэх сургалтын жилийн дундаж тохиолдлыг 300 хүнээр тооцоолов. /сургалт зохион байгуулах дундаж боломж/

$$4.5 \text{ цаг} * 300 = 1350 \text{ цаг}$$

Нийт цаг / нэг ажилтаны жилийн ажлын цаг = Хэрэгцээт ажилтны тоо

$$1350 \text{ цаг} / 1936 \text{ хүн/цаг} = 0,69 \text{ хүн} = 1$$

Долоо. Хуулийн төслийн 11.2.11. Төмөр замын тээвэрт гарсан сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан шалтгааныг шинжлэн судалж, шинжээчийн дүгнэлт гаргах, арга хэмжээ авч ажиллана:

- Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдлыг газар дээр нь шалгах комисс зохион байгуулах- ослын тохиолдол бүрт;
- Шалтгаан нөхцлийг тогтоох, дүгнэлт гаргах-ослын тохиолдол бүрт;
- Зөвлөмж гарган, ослоос урьдчилан сэргийлэх талаар мэдээ, мэдээлэл, заавар зөвлөмж гарган олон нийтийн сүлжээгээр сурталчлах- тогтмол.

Дээрх үүргийн дагуу хийгдэх ажил нь үргэлжилсэн шинжтэй тул тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээнд хамрагдана. Хуулийн төслийн 63 дугаар зүйлийн Төмөр замын сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсаныг шинжлэн шалгах, магадлах үүргийг

хэрэгжүүлэх бөгөөд хуулийн шаардлагад нийцсэн мэргэжлээр төмөр замд 10–иас доошгүй жил ажилласан тусгай мэргэжлийн 2-оос доошгүй боловсон хүчин шаардлагатай.

Найм. Хуулийн төслийн 11.2.12. Төмөр замын салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухаан технологийн бодлогыг хэрэгжүүлэх

- Төмөр замын салбарын хөгжлийн бодлого төлөвлөлтийн уялдаа холбоо хангах, стратеги инновацийн төлөвлөгөөг боловсруулах–жил бүр ,
- Салбарын урт хугацааны үр ашиг, өрсөлдөх чадварыг хангахад чиглэсэн шинэ нээлт санал, санаачлагыг дэмжих олон нийтийн үйл ажиллагаа зохин байгуулах-жилд 2 удаа;
- Салбарын стратегитай холбогдсон урт хугацааны төсөл хэрэгжүүлэх–1 удаа /3-аас дээш жил/
- Тулгамдаж буй асуудлын талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хийж сонин сэтгүүлд нийтлүүлэх, ном бичих, олон улсын хурал зөвлөгөөнд оролцох-тогтмол

Энэ заалт нь салбарт зайлшгүй хийгдэх тусгай үүрэгт хамрах бөгөөд тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээнд хамруулна. Шинээр нэг орон тооны ажилтан нэмэх шаардлагатай.

Ес. Хуулийн төслийн 11.2.13. Төмөр замын дэд бүтэц, салбар замын хувийн хэрэг хөтлөх, төмөр замын тээврийн салбарын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх

Арванхоёрдугаар хүснэгт

Дэд бүтэц, салбар замын хувийн хэрэг хөтлөх, салбарын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх зардлын тооцоо

Бүрдүүлэх баримт	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа, минут	Ажлын хөлс	Зардал
Бүртгэлийн өргөдөл	Өргөдөл хүлээн авах	15	124.21	1863.1
Холбогдох бичиг баримт бүрдүүлэлт	Хуулбар авах, И-мэйл ирүүлэх, нотариатаар баталгаажуулах	15	124.21	1863.1
Мэдээлэлийг шалгах, баримтыг тулгах	Тоо баримтыг хянах, зураглалыг бодит байдалтай тохируулж хянах	60	124.21	7452.6
Салбар замын хувийн хэргийг бүрдүүлэх	Олшруулах, нотариатаар баталгаажуулах	30	124.21	3726.3
Гэрчилгээ олгох	Програм хангамжид бүртгэх, хэвлэх	60	124.21	7452.6
Хувийн хэрэг архивлах	Стандарт ажиллагаа	60	124.21	7452.6
Мэдээлэлийн сан бүрдүүлэх	Бүх мэдээлэлийг оруулах	120	124.21	14905,2
Нийт		360	124.21	44715,1

ТАЙЛБАР: Хугацаа х Ажлын хөлс=Үйл ажиллагаа тус бүрийн зардал.

Хүний нөөцийн хэрэгцээ=Зарцуулах хугацаа×Тохиолдлын тоо
/Төмөр замын салбарт аж ахуйн нэгж салбар зам эзэмшиж байна. Төмөр замын салбар зам нь тусгай байгууламж тул төрийн бүртгэл мэдээлэл хяналтыг сайжруулах зайлшгүй шаардлагатай. Жилд дунджаар 300 объектийг хувийн хэрэгжүүлэх

$$6 \text{ цаг} * 300 = 1800 \text{ цаг}$$

Нийт цаг / нэг ажилтны жилийн ажлын цаг = Хэрэгцээт ажилтны тоо

$$1800 \text{ цаг} / 1936 \text{ хүн/цаг} = 0,92 \text{ хүн} = 1$$

Тоон үзүүлэлтийг үндэслэсэн урьдчилсан тооцоолол:

Хүний нөөцийн тооцооллыг гаргахдаа тухайн үүргийг гүйцэтгэх ажилтнуудын 2020 онд авч буй цалингийн дунджаас нэгж минутанд ноогдох цалингийн зардлыг тооцоолсон.

Арвангуравдугаар хүснэгт

Тухайн ажилтны ажлын хөлс

Сарын дундаж цалин	Жилд ажиллах хоног, ажлын цаг, минут			Сард ажиллах хугацаа		Ажлын хөлс	
	Жилд ажиллавал зохих хоног	Жилд ажиллах ажлын цаг	Жилд ажиллах ажлын минут	Сард 22 хоног	Сард зарцуулах минут	Нэг цагт ногдох цалин	Нэг минутад ногдох цалин
1 311 640	264 хоног	2112 цаг	126720 минут	176 цаг	10560 минут	7452.50	124.21

/1 минутад ногдох хөлсөөр тооцов/

Шинээр нэмэгдэх ажил үүрэгт шаардагдах ажилтны тоог тооцоолохдоо ажилтны ажлын хөлс, мэдээлэл бэлтгэн гаргахтай холбогдуулан хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлийн хугацаа, хэдэн удаа хэрэгжүүлэх давтамж зэргийг хийгдэх ажил, үйлчилгээ тус бүрээр нягтлан тооцож гаргасан болно. Жишээ нь:

Арвандөрөвдүгээр хүснэгт

Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдон гарах зардлын тооцооны дүн

Бүрдүүлэх баримт, материал	Стандарт үйл ажиллагаа	Нэгж зардал /төгрөг/	Тоон үзүүлэлт	Зардал
Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл	Өргөдөлтэй танилцах	4968	10.1	892082.5
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, санхүүгийн тайлангийн хуулбар	Хянан шалгах	14906		150550.6
Шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл	Хянан шалгах	7726		78032.6
Санхүүгийн чадавхын мэдээлэл	Хянан шалгах	3726		37632.6

Тусгай зөвшөөрлийн төрлөөс хамааран шаардлагатай тохиолдолд зураг төсөл.	Хянан шалгах	14905		150540.5
Холбогдох маягтын дагуу гаргах хуулийн этгээдийн мэдээлэл	Хянан шалгах	6405		64690.5
Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт	Хянан шалгах	19542		197374.2
Шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээллийг авах	Утсаар холбогдох	4968		50176.8
	И-мэйл илгээх			
Шийдвэрлэх	Төвийн удирдлагаар шийдвэрлүүлэх	11044		111544.4
Нийт		88325.00		1 732 624.7

Энэхүү дүгнэлт хэсэгт зардлыг тооцох үе шат бүхний хүрээнд хийгдсэн тооцооллуудаас жишээ болгон харуулсан болно. Дээрх тооцоонд тулгуурлан материалын болон бусад зардлыг тооцсон.

Арвантавдугаар хүснэгт

Шинэ хуулийн заалтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах материаллаг болон бусад зардлын тооцоолол

Хуулийн төслийн заалт	Материаллаг зардал	Бусад зардал	Тайлбар
11.2.6.	4 524 124.00	2 997 000.00	Хөдлөх бүрэлдэхүүн болон чингэлгийг бүртгэснээр, жилд гарах захиргааны зардал.
11.2.7.	2 800 985.00	2 400 650.00	томилолтын зардал, арчлалт засвар, тоног төхөөрөмжийн тохируулга.
11.2.8.	1 857 896.00	2 456 489.00	Төмөр замын тээвэрлэлтийн талаар иргэд байгууллагын гомдлыг хүлээн авах барагдуулах ажлыг зохион байгуулах ажлыг цахим системтэй болгох.
11.2.9.	18 560700.00	26 439 300.00	Радио зурвасын бүртгэл хөтлөх, газар дээр нь шалгах шинжээч нарын үйл ажиллагааны зардал.
11.2.10.	1 033 450.00	745 892.00	Сургалт зохион байгуулахтай холбогдох зардал.
11.2.11.	1 245 894.00	895 500.00	Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдлыг шалгах ажлын хэсгийн бүрэлдэхүүний томилолт, хувцас, тоног төхөөрөмж, ажлын хэрэгслийн зардал.
11.2.12.	0	0	Шинжлэх ухаан техникийн зөвлөл, хурал зохион байгуулах.
11.2.13.	3 789450.00	4 800 000.00	салбар замын бүртгэл хөтлөх, бүртгэлийн гэрчилгээ олгох, газар дээр нь шалгах шинжээчийн үйл ажиллагааны зардал.
	33 812 990.0	40 734831.0	НИЙТ 74 547821

Хуулийн шинэчлэлтэй холбогдон төрийн үйлчилгээ, зохицуулалт нэмэгдэх бөгөөд Төмөр замын тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын асуудал эрхэлсэн байгууллага нь улсын төсөвт 600 гаруй сая төгрөгний орлого төвлөрүүлэх боломжтой.

Арванзургаадугаар хүснэгт

**Шинэ хуулийн заалтуудыг хэрэгжүүлж төмөр замын
салбараас улсын төсөвт төвлөрүүлэх орлогын урьдчилсан тооцоолол**

Хуулийн төслийн заалт	Орлого /сая. төгрөг/	Тайлбар
11.2.6.	98.150.000	Хөдлөх бүрэлдэхүүн болон чингэлгийг бүртгэх.
11.2.7.	90.000.000	Баталгаажуулалтын шинжилгээний зардал.
	300.000.000	Туршилт шинжилгээний ажлын орлого.
	5.000.000	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай болон улсын тэмдэгтийн хураамж.
11.2.8.	-	Төмөр замын тээвэрлэлтийн талаар иргэд байгууллагын гомдлыг хүлээн авах барагдуулах ажлыг зохион байгуулах ажлыг цахим системтэй болгох.
11.2.9.	25.000.000	Радио зурвасын бүртгэл хөтлөх.
11.2.10.	36.000.000	2016, 2017 онуудад 45-60 хүн сургалтанд хамрагдсан ба 2018 оноос эрх зүйн үндэслэлгүй шалтгаанаар зогссон байна. Сургалт үргэлжилснээр 1 хүний сургалтын төлбөр 600.000 төг.р тооцож гаргасан болно.
11.2.11.	-	Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдлыг шалгах.
11.2.12.	-	Шинээр нэмэгдсэн чиг үүрэг.
11.2.13.	44.800.000	896 салбар зам тус бүрийн бүртгэлийн хураамж.
Нийт орлого		598.950.000.

Арав. Нийт зардлын дүнгийн тооцоолол:

Шинэ хуулийг хэрэгжүүлсэнээр төмөр замын салбарт 13 заалт бүхий чиг үүрэг түүнээс 7 заалт шинээр төрийн зохицуулалт хийх бөгөөд нийт зардлыг тооцож үзэхэд урьдчилсан байдлаар улсын төсвөөс 223068554 төгрөг шаардлагатай байна.

Арвандолоодугаар хүснэгт

Нийт зардлын дүнг тооцож үзэхэд: /Жилээр/

Хуулийн төслийн заалт	Шинэ орон тоо	Шинэ орон тооны цалин	Материаллаг зардал	Бусад зардал	Дүн
11.2.6	2	27 752 028.00	4 524 124.00	2 997 000.00	35 273 152.00
11.2.7	2	27 752 028.00	2 800 985.00	2 400 650.00	32 953 663.00
11.2.8	1	17 155 139.00	1 857 896.00	2 456 489.00	21 469 524.00

11.2.9			18 560 700.00	26 439 300.00	45 000 000.00
11.2.10	2	21 347 714.00	1 033 450.00	745 892.00	23 127 056.00
11.2.11	2	21 347 714.00	1 245 894.00	895 500.00	23 489 108.00
11.2.12	1	18 298 814.00	0	0	18 298 814.00
11.2.13	1	14 867 787.00	3 789 450.00	4 800 000.00	23 457 237.00
ДҮН	11	148 521.224.00	33 812 499.00	40 734 831.00	223 068 554.00

Зардал хэмнэх хялбарчлах боломжуудыг хэрхэн ашигласан талаарх дүгнэлт

Энэ хэсэгт хуулийн төсөлд шинээр нэмж байгаа буюу өөрчилж байгаа зохицуулалттай холбогдон гарах төсвийн зардлыг багасгах, эдийн засагт дарамт багатай өөр хувилбар боломж байгаа эсэхийг тооцсоныг товчхон дурьдав. 2007 оны хуулиар Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын төвд үндсэн 6 үүрэг байсан бөгөөд шинэ хуулийн зохицуулалтад тус үүргийг 3 заалтад нэгтгэж шинээр 10 заалтаар чиг үүргийг нэмэгдүүлсэн болно. Нэмэгдсэн үүргүүдийг аль болох хуучин орон тоонд давхар хариуцуулж хялбарчлах хэмнэх тооцоолол хийсэн.

Арван нэг. Баримтлах үндсэн зарчим:

Хуулийн төслийн шинэ заалтуудтай холбогдуулан гарах зардлыг тооцоходоо одоогийн байгаа орон тооны нөөц боломжийг ашиглаж болох эсэх:

Шинээр үүсэх чиг үүргийн дагуу материалын болон бусад зардлыг хэмнэх боломжийг харгалзан үзсэн болно. Ингэснээр хуулийн төслийн заалтаар нэмэгдэж буй чиг үүргийн хүрээнд шинээр 15 орон тоо бий болгох шаардлага үүссэн. Үүний 4 орон тоог одоогийн байгаа орон тоо хүний нөөцөд тулгуурлаж шийдвэрлэхээр тооцсон ба ингэснээр 4 орон тоо түүнд хамаарах бусад зардлыг тооцоход 54,1 сая /жил/ төгрөгийг хэмнэж байна.

Хуулийн төсөлд тус төвийн нэрийг **Төмөр замын тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын асуудал хариуцсан байгууллага болгон** өөрчилж, нийт 13 чиг үүргийг гүйцэтгэхээр тусгасан байх бөгөөд зардлын тооцоололд зардал тооцох аргачлалд заасны дагуу шинээр зардал гарахгүй болно.

Хуулийн төслөөр гүйцэтгэх үүргийг задалж өгсөн хэдий тус төв нь одоогийн байгаа орон тоогоор чиг үүргийг гүйцэтгэх боломжтой болно. Энэхүү хуулийн төслийн хэрэгжилтийг хангахад улсын төсөвт нэмэлт болон хүндрэл учруулахгүйгээр байх үнэлгээ гарч байна.

ТАНИЛЦСАН:

ДЭД САЙД Л.ХАЛТАР

ХЯНАСАН:

**ТӨМӨР ЗАМ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА: Б.АРТУР**

БОЛОВСРУУЛСАН

:

Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах
газрын Ахлах мэргэжилтэн **Т.МӨНХЦЭЦЭГ**

Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын
мэргэжилтэн **Д.ЖАВХЛАН**